



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Чоногол хөгжил ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СБА-2022/15/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Баруун-Урт
2022 он

Сүхбаатар аймаг дахь төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Нарантуяа

Утас: 99029193

Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Даваа

Утас: 99035990

Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК

Захирал: А.Сарангэрэл

Утас: 9988 4842

Цахим хаяг: gereltekhburtgelaudit03@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	6
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	7
3.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	7
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	7
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого.....	7
4. Аудитын тайлан.....	9
4.1 Ерөнхий зүйл.....	9
4.2 Дотоод хяналт.....	9
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	9
4.4 Материаллаг байдал.....	9
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	10
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	10
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	11
8. Аудитын илрүүлэлт.....	11
8.1 Төлбөрийн акт.....	11
8.2 Албан шаардлага.....	11
8.3 Зөвлөмж.....	12
9.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	12

Товчилсон үгийн жагсаалт

НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
НӨАУГ	Нийслэлийн өмчийн ашиглалт удирдлагын газар



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2022.02.16 № 141
танай _____-ны № _____-т

ОНГОН АРВИЖИХ ОНӨААТҮГ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ М.ЗОРИГТБААТАР
ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Онгон арвижих ОНӨААТҮГ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Онгон арвижих ОНӨААТҮГ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, тодруулгыг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд байгууллагын удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Байгууллагын удирдлага санхүүгийн тайлан, тодруулгыг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	27,529,817.61	6,749,674.1
1.1.2	Дансны авлага	14,345,781.24	21,065,677.07
1.1.4	Бусад авлага	-	-
1.1.6	Бараа материал	10,283,900.00	10,158,426.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	52,159,498.85	37,973,777.17
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	73,471,876.68	70,399,056.43
1.2.2	Биет бус хөрөнгө	990,000.00	990,000.00
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	74,461,876.68	71,389,056.43
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	126,621,375.53	109,362,833.6
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	9,741,867.3	7,487,963.00
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр		1,171,931.71
2.1.1.4	НДШ – ийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	65,475,874.46	63,293,345.31
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	75,217,741.76	71,953,240.02
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5	Хойшлогдсон орлого		-
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	75,217,741.76	71,953,240.02
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	-	-
2.3.9	Хуримтлагдсан ашиг	51,403,633.77	37,409,593.58
2.3.10	Өмнөх үеийн үр дүн	56,208.00	51,403,633.77
2.3.11	Тайлант үеийн үр дүн	51,347,425.77	(13,994,040.19)
2.3.11	Эздийн өмчийн дүн	51,403,633.77	37,409,593.58
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	126,621,375.53	109,362,833.6

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	237,237,489.86	251,094,335.56
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг(алдагдал)	237,237,489.86	251,094,335.56
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого		
8	Бусад орлого		
9	Борлуулалт, маркетингийн зардал	162,993,107.73	225,473,908.43
10	Ерөнхий ба удирдлагын зардал	22,496,956.36	38,724,467.32
12	Бусад зардал	400,000.00	890,000.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	51,347,425.77	(13,994,040.19)
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг (алдагдал)	51,347,425.77	(13,994,040.19)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	51,347,425.77	(13,994,040.19)
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
24	Орлогын нийт дүн	51,347,425.77	(13,994,040.19)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

Сүхбаатар аймгийн Чоногол хөгжил ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	54,728.00	54,728.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		1,480.0	1,480.0
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		51,347,425.77	51,347,425.77
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	51,403,633.77	51,403,633.77
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		(56,208.00)	(56,208.00)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		(13,994,040.19)	(13,994,040.19)
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	37,409,593.58	37,409,593.58

/Төгрөгөөр/

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	222,891,708.62	251,094,335.56
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	222,891,708.62	251,094,335.56
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого		
	Бусад мөнгөн орлого		
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	195,422,699.01	271,874,479.07
	Ажиллагчдад төлсөн	80,278,355.00	88,907,411.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	9,818,073.16	14,557,327.65
	Бараа материал худалдан авахад төлсөн	25,595,247.00	29,961,709.67
	Ашиглалтын зардалд төлсөн	33,253,044.79	56,820,351.00
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	12,489,650.00	16,992,080.00
	Хүүгийн төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн	2,135,047.68	31,950,767.32
	Даатгалын төлбөрт төлсөн		
	Бусад мөнгөн зарлага	31,853,281.38	32,684,832.43
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	27,469,009.61	(20,780,143.51)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Хүлээн авсан хүүгийн орлого		
2.2	Хүлээн авсан ногдол ашиг		
	Мөнгөн зарлагын дүн (-)		
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	27,469,009.61	(20,780,143.51)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	60,808.00	27,529,817.61
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	27,529,817.61	6,749,674.1

/Төгрөгөөр/

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
A	Орлого төвлөрүүлэлт	237,237,489.00	254,037,000.00	251,094,335.56	2,942,664.44	98.8
	Халаалт дулааны орлого	237,237,489.00	254,037,000.00	251,094,335.56	2,942,664.44	98.8
	Нийт дүн	237,237,489.00	254,037,000.00	251,094,335.56	2,942,664.44	98.8
	Цалин хөлс	80,278,355.00	107,139,464.00	101,500,549.00	5,638,915.00	94.7
	НДШ-ийн зардал	9,818,073.16	21,486,172.00	14,557,327.65	6,928,844.35	67.8
	Албан татвар хураамж /Машины татвар бусад/	2,135,047.68	18,120,590.00	40,765,058.43	(22,644,468.43)	225.0
	Бичиг хэргийн зардал	199,550.00	1,152,000.00	274,800.00	877,200.00	23.9

/Төгрөгөөр/

Сүхбаатар аймгийн Чоногол хөгжил ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Ашиглалтын зардал	33,253,044.79	60,560,000.00	56,820,351.00	3,739,649.00	93.8
Хангамжийн материалын зардал	23,503,946.32	8,502,000.00	8,017,816.67	484,183.33	94.3
Шатахууны зардал	25,395,697.00	29,908,000.00	21,673,893.00	(765,893.00)	103.7
Даатгалын зардал					
Утас, интернэт		684,000.00	672,000.00	12,000.00	98.2
Томилолт /унаа, буудал, хоол/		352,000.00	946,000.00	(594,000.00)	268.8
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардал	400,000.00	2,820,000.00	100,000.00	2,720,000.00	3.5
Банкны үйлчилгээний зардал	53,597.00		73,500.00	(73,500.00)	
Зар сурталчилгааны зардал			1,375,000.00	(1,375,000.00)	
Хөдөлмөр хамгааллын зардал	800,150.00	2,456,000.00	195,000.00	2,261,000.00	7.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал		960,000.00	1,125,000.00	(165,000.00)	117.2
Сэлбэг хэрэгсэл	11,689,500.00	8,500,000.00	16,992,080.00	(8,492,080.00)	199.9
Нийт дүн	187,526,960.95	253,640.226	265,088,375.75	(11,448,149.75)	104.5

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Чоногол хөгжил ОНӨААТҮГ-ын зорилгыг “Сумын нийт төсөвт байгууллага, аж ахуйн нэгжийг дулааны эрчим хүчээр найдвартай хангаж, орон нутгийнхаа хөгжилд, иргэдийн ая тухтай амьдрахад өөрсдийн чиг үүргийн хүрээнд манлайлал болж ажиллана” гэж тодорхойлсон байна.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг “Орон нутгийн өмчит нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт, ногоон байгууламж, автозам, гүүр шинэчлэлт хийх, дээрх нийтийн үйлчилгээний чиглэлээр болоод гэрэлтүүлэг, хог хаягдлын менежментийг сайжруулах төсөл хэрэгжүүлэх, хамгаалах хэтийн төлөвийг тодорхойлох, их болон урсгал засварын нэгдсэн төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх ашиглалтад хяналт тавих, төвлөрсөн хогийн цэгийн үйл ажиллагааг эрхлэх, нийтийн үйлчилгээг бүхэлд нь үзүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах, өөрийн үйлдвэрийн автомашин механизм, техник хэрэгсэл тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангах, цаашид хайрга, хөрс үйлдвэрлэл, мод үржүүлгийг хөгжүүлэх замаар сумын нийтийн үйлчилгээг хөгжүүлэхэд оршино” гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд орон нутгийн өмчийн статустай байна. Өмчийн 100 хувийг орон нутаг эзэмшиж байна.

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2017 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 06 дугаар тогтоолыг үндэслэн Чоногол ОНӨААТҮГ-ыг байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дүгээр зүйлд “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараахь бүрэн эрхтэй: ... 5/ орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих;...” гэсэн заалттай нийцэж байна.

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Засаг даргын 2017 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/131 дугаартай захирамжаар байгууллагын удирдлагыг томилсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Чоногол хөгжил ОНӨААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	27,529.8	6,749.7	20,780.1
Авлага	14,345.8	21,065.7	6,719.9
Бараа материал	10,283.9	10,158.4	125.5
Үндсэн хөрөнгө	73,471.9	70,399.1	3,072.8
Биет бус хөрөнгө	990.0	990.0	-
Нийт хөрөнгийн дүн	126,621.4	109,362.8	17,258.6
Өр төлбөрийн дүн	9,741.9	7,487.9	2,254.0
Богино хугацаат өглөг		1,171.9	1,171.9
Урьдчилж орсон орлого	65,475.9	63,293.3	2,282.6
Эздийн өмч	51,403.6	37,409.6	13,994.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	126,621.4	109,362.8	17,258.6

Хаан банкны 5642247170 тоот харилцах дансанд 6,749.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Авлагын үлдэгдэлд сумын ЭМТ-аас авах 2,825.1, сумын Ерөнхий боловсролын сургуулиас авах 14,577.2, Хүүхдийн цэцэрлэгээс авах 2,211.5, Ахмадын хорооноос авах 1,411.0, айл өрхөөс авах 40.9, нийт 21,065.7 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй байна. Авлагын дансны эцсийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Монгол улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дугаар тогтоолоор ус, дулааны төлбөрийг төрөөс хариуцан төлөхтэй холбоотой Эрчим хүчний яамнаас авах 25,390.8 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн аздаар баталгаажуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 10,158.4 мянган төгрөг болж, 125.5 мянган төгрөгөөр буурсан. Тайлант онд бараа материалын дансанд 68,592.0 мянган төгрөгийн худалдан авалт хийж, 68,717.5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 70,399.1 мянган төгрөг болж, 3,072.8 мянган төгрөгөөр буурсан. Үндсэн хөрөнгийн данс 1,730.0 мянган төгрөгийн худалдан авалтаар нэмэгдэж, 4,802.8 мянган төгрөгийн элэгдлийн зардлаар буурчээ.

Биет бус хөрөнгийн дансанд 990.0 мянган төгрөгийн үнэтэй Санхүүгийн Лидер-3 программ хангамж бүртгэгдсэн, тайлант хугацаанд өөрчлөлт ороогүй байна.

Богино хугацаат өр төлбөрийн дансны үлдэгдэлд НӨАТ-т өгөх 1,171.9, Эрдэнийн босго ХХК-д өгөх нүүрсний төлбөр 7,487.9, нийт 8,659.8 мянган төгрөгийн өр төлбөртэй байна.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Чоногол хөгжил ОНӨААТҮГ-ын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 06 дугаар тушаалаар Чоногол хөгжил ОНӨААТҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант

оны нийт орлогыг 254,037.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг 253,640.2 мянган төгрөгөөр, 396.8 мянган төгрөгийн ашигтай байхаар тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 251,094.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 265,088.4 мянган төгрөгийн зардал гарган, 13,994.0 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 251,094.3 мянган төгрөг болж төлөвлөснөөс 2,942.7 мянган төгрөгөөр дутуу буюу 98.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

Нийт зардлын гүйцэтгэл 265,088.4 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 11,448.2 мянган төгрөгөөр илүү зарцуулсан буюу 104.5 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь Сүхбаатар аймгийн Татварын албанаас 2017 оны орлогод нөхөн татвар, торгууль, алданги тооцсоноос татварт өгөх 14,870.2 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн, уурын зуухны гэмтэл гарснаас үүдэн тоног төхөөрөмжийн зардал нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Тайлант онд цэвэр алдагдал 13,994.0 мянган төгрөг болсон нь тайлант онд орлогын гүйцэтгэл 98.8 хувьтай дутуу биелсэн, зардлын гүйцэтгэл 104.4 хувиар илүү байгаа нь нөлөөлсөн байна.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Чоногол хөгжил ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг ахлах аудитор С.Дашдэндэв, аудитор Д.Галт-Эрдэнэ, аудиторовн туслах Э.Алтангэрэл, аудиторовн туслах Ч.Мөнхбаясгалан нар гүйцэтгэж, чанарын хяналтыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер Г.Даваа, Дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа, Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-ийн Чанарын хяналтын менежер Д.Батмөнх, Захирал А.Сарангэрэл нар хэрэгжүүлсэн.

Чоногол хөгжил ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан тодруулгыг Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-д 2022 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн/нийцээгүй, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд компанийн 2019-2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд Аймгийн санхүүгийн хяналт, аудитын алба дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Чоногол хөгжил ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангаас нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогоос 2.0 хувиар буюу 5,021.9 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80.0 хувиар буюу 4,017.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Чоногол хөгжил ОНӨААТҮГ нь 2021 онд нийт 246,514.6 мянган төгрөгийн 28 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 1 мэдээллийг ил тод байршуулаагүй, 74,732.3 мянган төгрөгийн 10 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан зөрчилтэй байна.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, ТБОНӨХБАҮХАТХ-ийн хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

МУЗГ-ын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

6.2. Өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнөх аудитаар 36,731.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгснөөс албан шаардлага 100 хувь, зөвлөмж 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	36,731.5	1	36,731.5	-	-	-
Төлбөрийн акт	-	-	-	-	-	-	-
Зөвлөмж	2	-	2	-	-	-	-
Нийт дүн	3	36,731.5	3	36,731.5	-	-	

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сүхбаатар аймгийн Чоногол хөгжил ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй байна.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 76,054.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 225.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,096.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд албан, шаардлага хүргүүлж, 74,732.3 мянган төгрөгийн шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмж өгөв.

8.1 Төлбөрийн акт

1. Нийт 13 ажилтны 5-12 сарын цалингаас ХХОАТ-ын хөнгөлөлт буруу тооцсоноос 15.7 мянган төгрөгийг илүү, 210.1 мянган төгрөгийн дутуу суутгасан.

ХХОАТ-ын тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.1-д " Энэ хуулийн 7.1-д заасан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо уг орлогоос эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг хасна", 23 дугаар зүйлийн 23.1-д "Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон

8.2 Албан шаардлага

Байгууллага нь нийт 4 хувь хүнтэй холбоотой 1,096.1 мянган төгрөгийн худалдан авалтыг татварын цахим системд бүртгээгүй, и-баримтаар нотлогдохгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т "Бараа ажил үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно", 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" заалт, "эрх ба үүрэг", "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

8.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудаст нийт 246,513.6 мянган төгрөгийн 28 мэдээллийг ил тод байршуулахаас 74,732.3 мянган төгрөгийн 10 мэдээллийг ил тод байршуулаагүй зөрчилтэй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.3-т заасан “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт болон аудитын хуулийн этгээдэд 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д / д	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал:											
1	Цалинг буруу тооцоолж олгосон	1	225.8			1	225.8				
2	Худалдан авалтыг Татварын цахим системд бүртгээгүй, И баримтаар баталгаажуулаагүй	1	1,096.1					1	1,096.1		
Дүн		2	1,321.9	-	-	1	225.8	1	1,096.1	-	-
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:											
1	Шилэн дансны цахим хуудсанд бүрэн мэдээлээгүй	1	74,732.3							1	74,732.3
Дүн		1	74,732.3	-	-	-	-	-	-	1	74,732.3
Нийт дүн		3	76,054.2	-	-	1	225.8	1	1,096.1	1	74,732.3